

**ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД
ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН 2025 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН
БАЙДЛААР ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТОВЧ ТАЙЛБАР**

2025.12.25

Мөнхбулаг

Есөнзүйл суманд 2025 оны зөвхөн 4 дүгээр улирлын байдлаар өссөн дүнгээр нийт 55 өргөдөл хүлээн авч үүнээс 55 өргөдлийг 100% шийдвэрлэж ажилласан байна. Ирүүлсэн нийт өргөдлүүдийн 100% бичгээр ирсэн бөгөөд бүртгэл хяналтын карт үүсгэн шийдвэрлэх ёстой хугацаанд нь шийдвэрлэж ажилласан байна. 2025 оны 04 дүгээр улирлын байдлаар ирүүлсэн өргөдлүүдээс хамгийн их буюу 23 ирүүлсэн буюу нийт өргөдлийн 41,8%-г Ажилд орохыг хүссэн өргөдөл эзэлж байна. Мөн газар хүссэн өргөдөл 23, Жирэмсний амралт хүссэн 2, Хүүхэд асрах чөлөө хүссэн 1, бусад асуудлын талаар 2, Ажлаас гарахыг хүссэн 4 өргөдөл тус тус ирж 55 өргөдлийг буюу 100 хувьтай шийдвэрлэн ажиллаад байна.

Сумын албан байгууллагуудаас 4 дүгээр улирлын байдлаар Засаг даргын Тамгын газарт нийт 40, Эрүүл мэндийн төвд ажилд орох, гарахтай холбоотой 7 өргөдөл, Соёлын төвд 8 өргөдөл ирсэн бөгөөд ирсэн өргөдлийг хууль, дүрэм журмын дагуу шийдвэрлэсэн байна. Байгууллагуудаас өргөдөл гомдлын мэдээг бэлтгэсэн маягтын дагуу цахим болон цаасаар баталгаажуулан авч ажиллаж байна. Албан байгууллага болон өргөдөл гомдол хүлээн авч буй албан хаагчдад “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн дагуу өргөдөл хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөгөөг өгөн сумын хэмжээнд мөрдөн ажиллаж байна.

ХЯНАСАН:

ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА С.БАТ-ЭРДЭНЭ

МЭДЭЭГ НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Т.МӨНХЗУЛ

